

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ХОРИННЭГДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны аравдугаар сарын 18-ны 12 цаг 10 минутад эхэлж, 13 цаг 00 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө) 50 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболдын 2017 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн ТГ/755 тоот албан бичгээр Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулахаар зарлахаар тогтов
2	Зарим албан хаагчдыг " Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнах тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.2.9, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: 1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачилгатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан энэхүү

		<p>тогтоолын хавсралтад нэр дурдсан төрийн албан хаагчдыг Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнах</p> <p>2. "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол, тэмдгээр шагнагдсан хүн бүрт уг шагналыг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг шагнуулахаар нэр дэвшүүлсэн тухайн байгууллага Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу шийдвэрлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүний тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.2 дахь заалт, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, 3.7.1, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн албаны үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах зорилгоор аймгийн Тамгын газрын даргыг хууль тогтоомжийн дагуу жинхлэн томилогдох хүртэл хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр батлах. Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга:</p>

		<ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга</li> </ul> <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн ерөнхий прокурор</li> <li>- Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор</li> <li>- Аймгийн Цагдаагийн газрын дарга</li> <li>- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга</li> <li>- Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга</li> <li>- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга</li> <li>- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга</li> <li>- Аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга</li> <li>- Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга</li> </ul> <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн</li> </ul> <p>2. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангахыг Ажлын алба /Д.Баатарсайхан/-д салбар зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад тус тус даалгах</p> <p>3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөлийн даргад үүрэг болгох</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар</p>
--	--	--

		<p>зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 2 дахь хэсэг, 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	<p>Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.7.3, “Дөрөв”-ийн 4.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын “Найм”-ын 8.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, зөвлөмж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан ерөнхий болон тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх Салбар зөвлөлийг 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс татан буулгах</p> <p>2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 63 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох</p>

		<p>3. Тус яам болон харьяа байгууллагуудад Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
5	<p>Төрийн албан хаагчдын хүний нөөцийн удирдлагын системийг шинэчилж байгаа талаар танилцуулах</p>	<p>Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан гаргах шинэчилсэн системийг хүлээж авахаас өмнө 2017 оны 11 дүгээр сарын 15-ны дотор системийг ажиллуулж танилцуулахыг үүрэг болгов</p>

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБА**